

Д.Сүхжаргалмаа

МОНГОЛЫН ТББ-УУДЫН САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

Сүүлийн хэдэн өдөр утас ашиглаж хийсэн миний “судалгааны” дүнг дурьдвас:

- ТББ-уудын санхүүжилтийн талаархи мэдээллийг нэгтгэж дүгнэх чадавхи ХЗДХ-ийн Яамны хувьд тун дутмаг
- СЭЗ-ийн Яамны Төсвийн газар нь бас мэдээлэлгүй харин ахмадын, эмэгтэйчүүдийн, хүүхдийн байгууллагад төсөв баталж өгөдгийг хэлэв.
- Мөн Яамны Төрийн сангийн газар ч мэдээлэл цуглуулж нэгтгэн дүгнэх аргачлал, механизм өнөөгийн байдлаар алга, энэ асуудлыг тавьж байгаа гэв.
- Салбар яам, орон нутагт “Төвлөрсөн арга хэмжээний зардал” хэмээх зүйл ангиар төсөв хуваарилдаг, үүнээс ТББ-ууд хүртдэг, эргэж тайлагнах нь сул тул эдгээр байгууллагад хандаж мэдээлэл хүсвэл илүү оновчтой болно гэв.
- ХЗДХ-ийн болон СЭЗ-ийн яамд өнөөгийн байдлаар ТББ-уудын санхүүжилтийн талаар мээдэлэл, дүн шинжилгээ хийх тогтолцоо байхгүй гэж хэлэх нь хэтрүүлэг болохгүй гэдгийг шууд хүлээн зөвшөөрч байна.

2002 ОНЫ БАЙДАЛ


- ХЗДХ-ийн Яаманд тайлангаа гаргасан байгууллага 185
- Үүнээс санхүүгийн мэдээ өгсөн 46
- Санхүүгийн мэдээ өгөх нэгдсэн аргачилалгүй юм байна. Иймээс хүн хүчний дутагдалтай байдалд түүнийг нэгтгэж дүн шинжилгээ хийх аргагүй.

Орлогын бүтэц:

○ Гишүүний татвар	Т. 4,456,766	/9 байгууллага/
○ Хандив	Т. 78,380,876	\$ 7,400
○ Орлого	Т. 111,307,681	\$ 75,840
○ Төсөл	Т. 99,486,350	\$ 926,328
○ ЗГ-аас авсан 2 төсөл	Т. 1,356,500	/1 байгууллага/
○ ЭЗ-ийн үйл ажиллагааны орлого	Т. 76,969,145	\$70 /6 байгууллага/
○ Passive income	Т. 603,100	\$500 /1 байгууллага/
○ Зээл	Т. 500,000	/1 байгууллага/
○ In-kind	Т.1,763,200	өртөг бүхий 800 ном
	Т. 200,000	өртөг бүхий хувцас
○ Төсөв	Т. 14,822	
○ Үндсэн хөрөнгө	<u>Т. 3,568,000</u>	
	Т. 378,606,440	\$ 1,010,138
• Зарлага	<u>Т. 42,535,225</u>	\$ 2,000
	Т. 421,141,665	\$ 1,012,138 /\$1,373,633/
		Байгууллагын дундаж: \$29,862

- Үндсэн хөрөнгөө мэдүүлсэн 1 байгууллага
- Дээрхи орлогыг ерөнхийд нь зарцуулсан, үлдэгдэлтэй байгууллага бараг үгүй

\$ 650,000 төсөл – 1 байгууллага, \$173,738 төсөл – 1 байгууллага



**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙГМИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА**

**УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, БИЗНЕСИЙН ТӨВ
ЗОХИСТОЙ ХӨГЖЛИЙН ЖЕНДЭР ТӨВ
ЗӨВЛӨХ НЭГЖ. ЗБН
ХАМТРАН ГҮЙЦЭТГЭВ**

Улаанбаатар хот 2000 он

Хандивлагчдын VII уулзалт: нийгмийн салбарыг хөгжүүлэхэд төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, энэ үйл ажиллагааны зорилтот түвшинг тодорхойлох үзүүлэлтүүд дээр санал нэгдсэн билээ. Парисийн уулзалтаар монголын нийгмийн салбарт үзүүлэх тусламжийн асуудлыг тусгайлан авч үзэхээр шийдвэрлэсэн.

Судалгааны зорилго: Хоёр болон олон талт хамтын ажиллагааны шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, цаашдын үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох.

Судалгаанд хамрагдсан ТББ-уудыг а/ ХЗДХЯ-нд бүртгэгдсэн ТББ-ын жагсаалт; б/ Нийгмийн асуудлын чиглэлээр олон нийтэд танил болсон байдал, нэр хүнд; в/ Үйл ажиллагааны идэвх; г/ Салбарын төлөөллөөр нь сонгосон

Судалгаанд дотоодын 80 ТББ, олон улсын ба гадаад донор орны 8 байгууллага хамрагдав.

Судалгааны агуулга, багтаамжийг: 1) Байгууллагын “паспортын” үзүүлэлтүүд; 2) Байгууллагын үйл ажиллагааных нь үндсэн чиглэл, зорилго, зорилтууд; 3) Хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төслүүдийн үндсэн үзүүлэлтүүд; 4) Байгууллагын чадавхи; 5) Байгууллагын санхүүжилт; 6) Байгууллагын ирээдүйн төлөв зэргээр хязгаарласан.

Анхдагч мэдээлэлд тоон ба утгын бүлэглэлт хийж, СОЦИО программаар боловсруулан, тайлан, санал-зөвлөмж бэлтгэсэн.

2000 ОН: 1,615 ТББ

	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Эзлэх хувь
1	Биеийн тамир спорт	216	13.37
2	Соёл урлаг	172	10.65
3	Найрамдал, хамтын ажиллагаа	138	8.54
4	Эдийн засаг, бизнес	124	7.68
5	Эрүүл мэнд	81	5.02
6	Хүүхэд залуучууд	78	4.83
7	Хөдөө аж ахуй	77	4.77
8	Эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ	77	4.77
9	Мэргэжил	71	4.40
10	Эмэгтэйчүүд, гэр бүл	66	4.09
11	Боловсрол	64	3.96
12	Иргэдийн эрх ашгийн хамгаалал	55	3.41
13	Шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэл	55	3.41
14	Байгаль орчин	38	2.35
15	Нэрэмжит сангууд	32	1.98
16	Өндөр настны үйлчилгээ	32	1.98
17	Энэрэнгүй үйлс, хүмүүнлэг тусламж үзүүлэх	31	1.92
18	Тахир дутуу иргэдийн үйлчилгээ	29	1.80
19	Нийгмийн хөгжлийн дэмжлэг	28	1.73
20	Бүс нутгийн хөгжил	28	1.73
21	Хүний эрх хамгаалал	23	1.42
22	Мэдээлэл сурталчилгаа	22	1.36
23	Шашин	22	1.36
24	Эрдэм шинжилгээ судалгаа	17	1.05
25	Аялал жуулчлал	15	0.93
26	Сонирхлын бүлгүүд	13	0.80
27	Бусад	11	0.68


4. ТББ-ын орлогын эх үүсвэр, зарцуулалт

Төрийн бус байгууллагын орлогын эх үүсвэр нь:


- Гишүүний хандив, татвар,
- Иргэд, аж ахуй нэгж, байгууллагын хандив,
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого,
- Зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө,
- Олон улсын байгуулага, гадаад орны төслийн санхүүжилт зэргээс бүрддэг ажээ.

Төрийн бус байгууллагын тухай Монгол улсын хууль батлагдаад дөнгөж 3 жил болж буй ч ТББ-ууд олноор үүсэн байгуулагдаж, нийгэмд зохих ёсоор байр сууриа олж, гүйцэтгэх үүрэг нь тодрон, ардчиллын ололт, иргэний нийгмийн төлөвшлийг илэрхийлж байна.

**ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн
төрөл хэлбэр, санхүүжилт
Нийт 302 төсөл**




- Төсөл, хөтөлбөрийн тоо жил бүр өсөж, түүнд хамрагдах байгууллага, хүмүүс, үйл ажиллагааны чиглэл, асуудлын цар хүрээ нь нэмэгдсэн байна
- ТББ-уудын санхүүгийн болон ажил гүйцэтгэх чадавхи нэмэгдэж нийгэмд гүйцэтгэх үүрэг нь өсөж байгааг харуулж байгаа үзүүлэлт гэж хэлж болохоор байна.
- Төсөл хэрэгжүүлж байгаа ТББ-ын тоо ч жилээс жилд нэмэгдсэн байна.



- Төслүүдийн үйл ажиллагааны гол чиглэлүүд:
 - нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх /нийгмийн эмзэг хэсэгт туслалцаа үзүүлэх, ядуурал ажилгүйдлийг бууруулах г.м./,
 - нийгмийн асуудлын чиглэлээр нийгэмд болон гишүүддээ үйлчилгээ үзүүлэх /хүний эрх ардчилалыг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах/,
 - сургалт явуулах, шинэ мэдээлэл дамжуулах

Нийт	4,426,700,000 төгрөг
Дотоод эх үүсвэрээс	298,700,000 төгрөг
Гадаад эх үүсвэр	4,128,000,000 төгрөг
Харьцаа	6.7:93.3



- Гадаад эх үүсвэр зонхилдог хандлага ойрын ирээдүйд хадгалагдах болов уу хэмээн судалгааны таамаг хийж байна.
- Монголд байнгын үйл ажиллагаа явуулдаг донор 8 байгууллагын гаргасан судалгаагаар 1996-2000 онд тэдгээр байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нийт 170 төслийн хэд нь ТББ-уудын оролцоотойгоор хэрэгжсэн нь тодорхойгүй байна.
- Судалгаанд хамрагдсан ТББ-уудын дийлэнхи олонхи нь буюу 76 байгууллага өөрийн үйл ажиллагааг Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй уялдаатай гэж үздэг байна. Эндээс нэгэн зүйлийн дүгнэлт хийхэд төр, засгийн нийгмийн бодлого, дэвшүүлсэн тодорхой зорилтууд нь энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг “төрүүлдэг” бололтой юм. ТББ-ын үйл ажиллагаа ба засгийн газрын бодлого, хөтөлбөр нь дараах чиглэлүүдээр илүү түлхүү уялдаж, давхцдаг гэсэн санааг судалгаанд хамрагдсан ТББ-ууд илэрхийлжээ. Үүнд:
 - Хүүхэд залуучуудын хөгжил, боловсролын салбар;
 - Нийгмийн эмзэг бүлгийг тэтгэн дэмжих;
 - Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлаас гаргах;
 - Биеийн тамир, спорт, эрүүл мэндийн салбарын ажлыг дэмжих;
 - Чөлөөт хэвлэл, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх;
 - Бизнесийн хөгжлийг дэмжих, нийгмийн амьдралын бүх хүрээний менежментийг сайжруулах;
 - Судалгаа хийх, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих;
- Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах;
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах;
- Гадаад харилцааг хөгжүүлэх, улс хоорондын найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг болно.
- Зориуд тэмдэглэх нь: үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн уялдаа байгаа ч хамтран ажиллах нь үгүй байна.

3. ТББ-ын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхи

- Судалгаанд хамруулсан 80 ТББ, мөн донор 8 байгууллагаас авсан судалгааны дүнд тулгуурлан Монголын ТББ-уудын чадавхийг тодорхойлж байна.
- Ингэхдээ тухайн байгууллагын хүний нөөц (орон тооны ажиллагчдын тоо), жилийн зардал, үндсэн хөрөнгийн хэмжээ (балансын өртгөөр), гишүүд, дэмжигчдийн тоо, орон нутагт салбартай эсэх зэрэг орцын тоон үзүүлэлтүүдийг үндэс болгосны дээр ТББ-ын үйл ажиллагааны тогтвортой байдал, нэр хүнд зэргийг харгалзсан болно.

Хүснэгт 5

Судалгаанд хамрагдсан ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл

	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Хувь
1	Нийгмийн салбарын тодорхой асуудалд анхаарал хандуулах, шийдвэрлэх	20	25.0
2	Нийгмийн чиглэлээр гишүүддээ болон нийгэмд үйлчилгээ үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	18	22.5
3	Тодорхой салбарт мэргэжлийн үйл ажиллагаа явуулах	14	17.5
4	Сургалт явуулах, мэдээлэл түгээх	12	15.0
5	Судалгаа хийж, зөвлөгөө өгөх	10	12.5
6	Бизнесийн хөгжлийг дэмжих	4	5.0
7	Найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх	2	2.5
	ДҮН	80	100

а. Жилийн зардал

- ТББ-уудын бүртгэл, тооцооны систем цэгцрээгүй, энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутмаг, тогтвор суурьшилтай ажилладаггүйгээс хамааран олонхи ТББ жилийн зардлаа нарийвлан тооцдоггүй байна.
- ТББ-ууд судалгаанд зориулж зардал, санхүүжилтээ ил гаргах сонирхол багатай байдаг бололтой. Үүнийг 1996–1997 оны байдлаар 35, 1998 оноор 46, 1999 оноор 55 байгууллага тоо мэдээгээ гаргаж өгсөн явдал нотолж байна.
- ТББ-уудын жилийн зардал нь асар их ялгаатай, 1996–2000 оны хооронд дунджаар 1.0-ээс 315 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байжээ.
- Судалгаанд хамрагдсан олонхи байгууллагуудын хувьд (1999 оны байдлаар нийт байгууллагын 72.9%) жилийн дундаж зардал нь 5.0-19.0 сая төгрөг байгаа гэж тоймлож дүгнэхээр байна.
- ТББ-уудын санхүүгийн чадавхи жилээс жилд дээшилж ирсэн гэж үзэх байна. Зөвхөн 1996-1999 онд 20.0 сая төгрөгөөс дээш жилийн зардалтай ТББ-ын тоо 1.6 дахин нэмэгдсэн баримт үүнийг нотолно.

ТББ-уудын үйл ажиллагааны жилийн зардал

(мэдээлэл өгсөн байгууллагын тоо, хувиар)

Жилийн зардал /сая төг/	1996–1997 он		1998 он		1999 он	
	тоо	хувь	тоо	Хувь	тоо	хувь
50-иас дээш	3	8.6	4	8.7	6	10.9
40 – 49	1	2.9	1	2.2	-	-
30 – 39	3	8.6	6	13.0	5	9.1
20 - 29	3	8.6	1	2.2	5	9.1
10 – 19	8	22.9	7	15.2	10	18.2
5 – 9	6	17.1	7	15.2	8	14.5
5 хүртэл	11	31.4	20	43.5	21	38.2

Дүн	35	100	46	100	55	100
------------	-----------	------------	-----------	------------	-----------	------------

- Жигд бус байдал: Судалгаанд хамрагдсан ТББ-уудын бараг тэн хагас нь жилд 5 сая хүртэл төгрөг зарцуулж үйл ажиллагаагаа явуулдаг ажээ.

б. Хүний нөөц

- Хүний нөөц нь аливаа байгууллагын гол орц болж чадавхийг илэрхийлнэ
- Дунджаар 1996-1999 онд нэг ТББ-д 11 ажилтан ноогдоно
- Байгууллагуудаар хуваарилагдсан байдал нь жигд биш

ТББ-уудын ангилал

(Ажиллагчдын тоогоор)

Ажиллагчдын тоо /хүн/	1996–1997 он		1998 он		1999 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
50-иас дээш	1	2.1	1	1.7	2	2.9
40 – 49	1	2.1	1	3.4	2	2.9
30 – 39	3	6.3	1	1.7	2	2.9
20 – 29	-	-	-	-	-	-
10 – 19	10	20.8	14	24.1	16	23.5
5 – 9	10	20.8	10	17.2	13	19.1
5 хүртэл	23	47.9	30	51.7	33	48.5
Дүн	48	100	58	100	68	100

ТББ-уудын 47.9-51.7 хүртэлх хувь 5 хүртэл ажиллагчтай, хоёрхон байгууллагаа 50-иас дээш ажиллагчтай

- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүний тоо гол биш ч гэсэн ТББ-уудын олонхи нь энэ ажилд гаднаас хүн хүч татан оролцуулах шаардлагатай байдаг ажээ.

Үндсэн хөрөнгө

- Судалгаанд хамрагдсан ТББ-уудаас 1996-1997 онд 29, 1998 онд 39, 1999 онд 45, 2000 онд 52 нь өөрийн гэсэн үндсэн хөрөнгөтэй гэж хариулжээ.
- 2000 оны байдлаар 7 байгууллага 60.0 саяаас дээш төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байр/
- Олонхи нь буюу 55.8 хувь нь 5.0 сая хүртэл төгрөгийн үндсэн хөрөнгөтэй /үйл ажиллагаа явуулах оффисийн тавилга, техник хэрэгслэлийн төдий/
- Улсын бүртгэлтэй ТББ-уудын дөнгөж 10 орчим хувь нь өөрийн байртай гэсэн мэдээлэл байна.
- Эндээс үзэхэд манай орны ТББ-уудын материаллаг бааз сул, дөнгөж бүрдэх шатандаа яваа нь тодорхой. Үүнийг ТББ-ууд өөрийн давуу ба сул талаа үнэлсэн үнэлгээгээр ч нотолсон байна.
- Судалгаанд хамрагдсан бүх байгууллага утастай, 65 нь факстай, 43 нь электрон шуудан ашигладаг байна.

ТББ-уудын санал бодол

- “Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ТББ-ын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх арга замуудыг дурьдана уу?”, “Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд ТББ-ын давуу ба сул талыг дурьдана уу” гэсэн нээлттэй асуултуудаар авсан 136 хариулт

	Тоо	Хувь
Санхүүгийн дэмжлэг авах	43	31.6
Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх	15	11
ТББ-ын тухай хуулийг боловсронгуй болгох	14	10.3
ТББ-ын ажлын арга барил, хамтын ажиллагааг сайжруулах	14	10.3
ТББ-ын өрсөлдөгчийг бий болгох	13	9.6
Боловсон хүчнийг чадваржуулах	9	6.6
ТББ иргэний нийгмийн шинжийг төлөвшүүлэх	9	6.6
ТББ-ын гадаад харилцааг өргөжүүлэх	7	5.1
Мэдээлэл, хангамжийг сайжруулах	4	2.9
Төрөөс ТББ-уудыг санхүүгийн хувьд дэмжих	3	2.2
Зорилтот бүлэгтэйгээ ажиллах	3	2.2
Судалгаа хийх	2	1.5
Дүн	136	100

- ТББ-уудын бараг 1/3 нь гадаад, дотоодын санхүүгийн дэмжлэг авбал нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх тодорхой үүрэг гүйцэтгэх боломжтой гэжээ.
- Үүнийг бэлэнчлэх, гаднын тусламж дэмжлэг авах сэтгэлгээний илрэл гэхээс илүү манай орны ТББ-уудын санхүүгийн дэмжлэг хүлээн авах, шингээх чадавхи бий болчихоод байхад донор орон, байгууллагуудын нэгэнт амалчихсан зээл, тусламжийг гол төлөв манай талаас шалтгаалан бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй санхүүгийн хомсдолд орох болсонтой холбож үзвэл зохилтой.
- Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ТББ-ын үүргийг дээшлүүлэхэд Засгийн газар зарим чиг үүргээ гэрээний үндсэн дээр ТББ-аар гүйцэтгүүлэх явдал чухал ач холбогдолтой хэмээн 10 байгууллага тутмын нэг нь үзжээ. Энэ нь манай оронд явагдаж буй захиргааны шинэчлэлийн үзэл баримтлалтай нийцэж байгаагаараа ач холбогдолтой юм.
- ТББ-уудын дунд өрсөлдөөн бий болгох явдал тэдгээрийн нийгмийн үүргийг дээшлүүлэхэд багагүй ач холбогдолтой гэж нэлээд байгууллага үзэж байна.
- ТББ-уудын хооронд өрсөлдөөн сул байгаагаас нэг талаас Засгийн газрын, нөгөө талаас зарим нэг ТББ-уудын монополь шинж байна гэсэн зовнил зарим байгууллагуудад төрсөн нь харагдав.

Төслийн санхүүжилтэд UNDP, TACIS, DANIDA, JAIKA, USIAD, MFOS, DAD, AusAID, Английн ХИС сан зэрэг байгууллагын санхүүжилт зонхилж ирсэн байна.
